

## ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ХӨТӨЛБӨР

### БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

**Төслийн нэр:**

Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр

**Хугацаа:**

2012 – 2018

**Төсөв:**

8.3 сая шв.франк

**Зорилтот бүлэг:**

Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг эрхлэх газар,  
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар,  
Сангийн яам,  
Салбарын яамд,  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,  
Улаанбаатар хотын дүүрэг, хороод,  
Иргэний нийгмийн байгууллагууд,  
Иргэд

**Зорилтот бүс нутаг:**

Үндэсний хэмжээнд

Төвлөрлийг сааруулах нь иргэдийн оролцоотой, эрх тэгш хөгжлийг хангахад чухал гэж үзэн Монгол Улсын Засгийн газар 2011 онд төвлөрлийг сааруулах шинэтгэлийн асуудалд онцгойлон анхаарч, энэ үйл явцад дэмжлэг үзүүлэхийг Швейцарийн Холбооны Улсаас хүссэн юм. Улмаар 2012 оноос эхлэн Швейцарийн хөгжлийн агентлаг Монгол Улсын Засгийн газартай хамтран Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр (ЗДТСХ)-ийг хэрэгжүүлж ирсэн билээ. Төвлөрлийг сааруулах шинэтгэлийн үр дүнд өнгөрсөн хугацаанд шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоо орон даяар нэмэгдсэн юм.



© ШХА / Д. Давааням

Орон нутагт шийдвэр гаргах үйл явцад иргэд улам идэвхтэй оролцож, санал бодлоо илэрхийлдэг болж байна. Ховд аймгийн ЗДТГ-ын Иргэний танхимд болж буй хурал.

### ҮНДЭСЛЭЛ

2011 онд батлагдаж, 2013 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гаар дамжуулан улсын төсвөөс орон нутгийн төсөвт санхүүжилт олгодог болсон юм. ОНХС бий болсноор нутгийн удирдлага нь орон нутгийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх илүү их эрх мэдэлтэй болсон төдийгүй ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн чиглэлийг иргэдтэй зөвшилцөхөөр зохицуулсан. ОНХС-г бий болгосон нь төсвийн төвлөрлийг сааруулах,

иргэдийн оролцоог дэмжих чухал алхам болсон билээ. Төсвийн тухай хуулиас гадна өнгөрсөн хугацаанд иргэдийн оролцоог дэмжсэн хэд хэдэн шинэ хууль батлагдсан юм. Монгол Улсын Засгийн газраас ардчилал, төвлөрлийг сааруулах шинэтгэлийг цаашид үргэлжлүүлэх хүсэл эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлсний дагуу Засгийн газрын энэхүү ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор ЗДТСХ-ийг хэрэгжүүлсэн өмнөх туршлага, хүрсэн үр дүнг харгалзан хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан болно.

### ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

### ЗОРИЛГО

ЗДТСХ-ийн зорилго нь нутгийн удирдлагыг эрх мэдэлтэй, ардчилсан, иргэдийн өмнө хариуцлага хүлээдэг, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг тогтвортой хүргэдэг болоход дэмжлэг үзүүлэхэд оршино.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ГУРВАН ЧИГЛЭЛ

- **Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг:** Нутгийн удирдлагын байгууллагын чиг үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой болгох, захиргааны эрх мэдэл, хөрөнгө нөөцийг тэнцвэртэй хуваарилахад чиглэсэн бодлого, хууль, дүрэм журмыг Засгийн газар боловсруулна.
- **Иргэдийн оролцоо:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас шийдвэр гаргахад иргэдийн бодит оролцоог хангах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. Швейцарь Улсад хэрэглэдэг иргэдийн санаачлагаар хийдэг ард нийтийн санал

## ЗДТСХ-ИЙН НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ ҮР ДҮН

- ЗДТСХ I-ийн хүрээнд Монголд төвлөрлийг сааруулах, шууд ардчиллыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын чухал баримт бичгүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн юм. Мөн хууль тогтоомжийг боловсруулж, хэрэгжилтийг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах зорилготой Хууль тогтоомжийн тухай хуулийг батлахад хувь нэмэр оруулсан билээ.



© ШХА / Д. Даваням

Орон даяар нийт 150 гаруй Нэг цонхны үйлчилгээний төвүүд иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.

- Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулсан Нэг цонхны үйлчилгээ (НЦҮ)-ний төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас холбогдох журмыг баталж, НЦҮ-ний бүтэц, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн юм. Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр байгуулсан 45 НЦҮ-ний төвөөс гадна өнөөдөр аймаг, дүүргийн удирдлагын санаачилгаар сум, хороодод байгуулсан 150 гаруй НЦҮ-ний төв иргэдэд үйлчилгээ



© ШХА / Д. Даваням

Ховд аймгийн Жаргалант сумын иргэд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг голчлон автозам, явган хүний болон дугуйн зам барих төслүүдэд зарцуулахаар шийдвэрлэсэн байна.

асуулгыг Монгол Улсын онцлог болон эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн загвар болгон ашиглана.

- **Хотын засаглал:** Гэр хорооллын иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтыг төлөвлөж, хэрэгжүүлэх чиглэлээр Улаанбаатар хотын төр захиргааны байгууллагуудын чадавхи дээшилнэ. Төслийг хэрэгжүүлэх явцад иргэдийн оролцоог хангах, ингэхдээ үр шимийг нь эмзэг бүлгийн иргэдэд хүртээхэд анхаарч ажиллана.

үзүүлж байна. НЦҮ-ээс үзүүлж байгаа төрийн үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамж 80 орчим хувьтай байгаа нь үйлчилгээ авахад иргэдийн зарцуулж буй цаг хугацаа болон зардлыг багасгахад НЦҮ хувь нэмэр оруулж байгааг харуулж байна.

- Төрийн болон орон нутгийн төсвөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тогтолцоог бэхжүүлэх шинэтгэлийг дэмжсэний үр дүнд 39 суманд худалдан авах ажиллагааны үйл явц илүү нээлттэй, ил тод болон өрсөлдөөнтэй болсон юм. Тухайлбал, орон нутгийн түвшинд худалдан авах ажиллагааг зохион байгуулах чадавх сайжирч, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал нэмэгдэж, иргэний нийгмийн байгууллагууд худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавьдаг болсон зэрэг нааштай үр дүн бий болсон байна.

- Нутгийн удирдлагын байгууллагын үүрэг хариуцлага болон иргэдийн оролцоог зохицуулсан хууль тогтоомжийн талаарх иргэдийн ойлголт, мэдлэг сайжирсан. ЗДТСХ-ийн хүрээнд оролцоо бүхий ил тод засаглалыг дэмжсэнээр 17 суманд иргэдийн оролцоо (ОНХС-ийн хэлэлцүүлгийг оруулан) 14 хувиар нэмэгдсэн байна.

## Хамтран хэрэгжүүлэгч түншүүд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар (Швейцарийн Ардчилал судлалын төвийн дэмжлэгтэйгээр)
- Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг эрхлэх газар болон Сангийн яам (Швейцарийн Люцерний хэрэглээний шинжлэх ухаан, Урлагийн их сургуулийн дэмжлэгтэйгээр)
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр)

## Холбоо барих:

### Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр

Скай Плаза Бизнес төв  
2 давхар, Олимпын гудамж 12,  
Хороо 1, Улаанбаатар хот,  
Монгол Улс

Утас: +976 11328848

Факс: +976 11331420

Имэйл: ulaanbaatar@gdp.mn

## Монгол дахь

### Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Скай плаза бизнес төв,  
Олимпын гудамж 12,  
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,  
Улаанбаатар хот

Ш/Х 37, Улаанбаатар 14210,  
Монгол улс

Утас: +976 11 331 422

Факс: +976 11 331 420

И-мэйл: ulaanbaatar@eda.admin.ch  
Вэб хуудас: www.swiss-cooperation.  
admin.ch/mongolia